



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/Б04

Булган

Эрх шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хутаг-Өндөр сумын Хантай баг/, Хог хаягдлын цэгийг дарж булах, өөр газар шилжүүлэх /Хутаг-Өндөр сумын Хонгор баг/ гэх зэрэг төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулахад мэргэжлийн байгууллагуудын оролцоог ханган хамтарч ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх, эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газарт даалгасугай.

3. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ



20190205